



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

11
АНГИ

МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

Санамж:

- ✓ Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын 22 даалгаврыг 40 минутад гүйцэтгэх тул цагаан сайтар төлөвлөж бүх даалгаврыг ажиллаарай.
- ✓ Монгол хэлний даалгавруудыг гүйцэтгэхдээ эхийг уншиж, сайтар ойлгосон байхыг анхаараарай.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Буйр нуур нутгаа сахина, буцаж сэргэхгүй усаа шавхана

Орчин үед Монгол төдийгүй хотожсон, иргэншсэн болгонд тархиныхаа ядаргааг тал нутгаар тайлах онош гараад байна. Тэр эмчилгээг хийдэг газар дэлхий дээр ганцхан үлдсэн. Тэр нь Дорнод Монголын хялганат тал нутаг. Цагаан зээрээр давлагаалсан онгон зэлүүд байгаль. Үхтлээ хамгаалж, үгүйртлээ хадгалж баймааж авч хоцрон, өнөөдөр хүн төрөлхтөнд бэлэглэж буй Дорнын их тал минь юм сан. Дээгүүр нь машинтай давхих нь байтугай гишгэхэд хиртэм орчлонд ганц хувь үлдсэн гудас билээ.

Аялж жуулчлахад хамгийн аятайхан газрын тоонд CNN-ийнхэн манай Монголын Хөвсгөл, Тэрхийн цагаан нуурыг багтаасан гэнэ. Тэнд ч сайхан л даа. Уг нь Дорнын тал түүн дээр орших Буйр нуурыг хамгаалалтдаа аваад нэмээд жаахан тохижуулчих юм бол дэлхийд өрсөлдөгчгүй гайхамшигт аяллын бүс нутаг болох боломжтой.

“Газар нутаг бас ингэж хамаагүй хязгааргүй үргэлжилдэг гэж үү?. Болоогүй юу?” гэж анх очсон хүн болгон гайхдаг. Гайхахаар, дээр нь гайхамшигтай орчин л жинхэнэ аялал байдаг. Талыг туулах зам тувт л ямар нэгэн алсын өөд өгсөөд л байх шиг. Буцаад давхихад бас л өгсөөд буй мэт. Тэгснээ аль зүгт яваа зүг чиг алдарна. Халиурсан их өвсөн дунд замгүй бол бүх багцаа баримжаа дуусаа гэсэн үг. “За байз, тэр уулыг тойрсон билүү” гэх тэмдэггүй орчинд хүнийг балмагдуулна. Тохой өндөр өвсний ёроолоор зулсан зам арван алхмын цаанаас яаж харагдах вэ. Энэ зам тэр гүдгэр дээгүүр давчхаж гэх хараачлал байхгүй болчихлоор ертөнц дээр цор ганцаараа хоцорсон мэт сэтгэгдэл төрдөг.

Хамт яваа хүмүүстээ “Та нарт Буйр нуурыг харуулна аа” гэж ёстой залхааж орхисон. Тал нутагт жижиг сажиг нуур тогтоол хуртай жил бол элбэг. “Энэ нөгөө нуур чинь мөн үү” л гэнэ. Тэгж тэгж их талын хаяанд хэсэгхэн элсэн манхан гараад ирнэ. Тэр нь зам засварын овоолсон шороо шиг өчүүхэн намхан. Элс юм болохоороо машин тэрэг суулган барин сүлжээд тойрмогц өөдөөс мэлтийсэн том далай палхийтэл гараад ирнэ. Хүн эхлээд савж унатлаа цочин арагш өөрийн мэдэлгүй ухрах ба төд удалгүй бүх биеэр сэрүү татан тааламжтай сайхан чийг амьсгалан бие тавирна. Байгалийн энэ сонин тогтолцоо концерт эхлэх гээд хөшиг нээгдэж, гэрэл асаах лугаа санагдуулна. Тэнгэр хажуулдаж, сарыг сульдаадаг болов уу гэмээр энэ уудамд энүүхэн зам ч, тэртээх нуур ч дөрөө шүргэх өвсний цаана нуугдана. Буйр нуур уул биш болохоор яахин овойж алсаас харагдах билээ. Наян километр урт, хорин километр өргөн агуу их усны цаад эргийг хэн ч олж харж чадахгүй. Тийм учраас хөл дороос эхэлсэн тэнгэрийн хаяа усаар эхэлж тийшээ, дээшээ, арагшаа, хаашаа л бол хаашаа хязгааргүй цэлийлгэнэ. Нуурын тунгалаг бүлээн ус руу хөлөө дүрэхэд дор нь торгон элс шаргалтан байна. Ус ердөө төө хүрэхгүй гүнзгий. Талын нуур ийм онцлогтой. Нуурын гүн тийш бараа тасартал алхаж болно. Цаашлах тусам сэм сэмхнээр гүнзгийрээд л байна.

Сүүлийн жилүүдэд харин Халхын голд тариа ногоо тарьж, дээр нь ган гачиг болсноос талын нуур аажмаар ширгэж байна. Нуурын хойд эрэг нь Хятадын нутаг. Эрэг нь хоцорч нуур нь наашаа ирж явна. Эрэг дээр хятадууд загасны үйлдвэртэйгээ хоцрох юм уу эсвэл нуураа дагаад наашаа нутгаа тэлэх үү гэдэг асуултын тэмдэг тэнд үүсэж байна. Ийм тохиолдлыг чухам яаж шийддэг юм бол. Хөвсгөл нуур Эг, Сэлэнгээр дамжин Байгал нуурыг дүүргэдэг шиг Буйрт бас өөрийн гэсэн үүрэг бий. Тэр нь өөрөөсөө хэд дахин том

Далай нуурыг тэтгэж байдаг. Орос, Хятад хоёр том хөршийнхөө хоёр том нуурыг Монголын “Хөвсгөл Увс Буйрын гүн цэнхэр нуурууд...” ийн амьдруулдаг бөлгөө.

Эзэн Чингисийн ээж хатдын өлгий эртний Хонгирад аймаг, одоогийн Дорнод аймаг, Чойбалсангийн Буйр нуур элдэв домгийг дотроо залгин үл цалгин дүнсийнэ. Нуурын ус цагариг үүсгэн дотогшоо огшиж бууриа харьд үлдээнэ. Халхын гол эргэж Монгол руугаа урсан сайраа бас харьд үлдээнэ. Мэнэнгийн талд мэлтийсэн их ус хаашаа ч явалгүй нутгаа сахина. Монголоо манана. Монголчууд нь харин нуураа загастай нь, талаа газрын тостой нь тариагаа талбайтай нь гадаадынханд өгцгөөнө.

Тэглээ ч гэсэн эх орондоо хайртай Буйр нуур очсон болгоныг хайраараа бүүвэйлэн тэнхрүүлж өгөөд буцах цаг дор гунигтайяа алс тэртээд бүртийн хоцорно.

Ж.Гангаа

Монгол хэлний даалгавар

1. Эхийн дэвшүүлсэн асуудал юу вэ?
 - A. Буйр нуур Монголоо манан, нутгаа сахиж байхад Монголчууд нь харин газар нутаг, баялгаа гадаадынханд өгч байна.
 - B. Нутгаа сахиж үлдсэн ганц нуур нь Буйр нуур бөгөөд бусад нуурууд хөрш улсуудын томоохон нууруудыг тэтгэдэг.
 - C. Цаад эрэг дээр хятадууд загасны үйлдвэртэйгээ хоцроход хүртлээ ширгэсэн бөгөөд ус нь буцаж сэргэхгүй байна.
 - D. Эх орондоо хайртай Буйр нуур очсон болгоныг хайраараа бүүвэйлэн тэнхрүүлж өгөөд усаа ширгээж үлддэг.
2. Эхийн гол санааг илэрхийлэх өгүүлбэр аль вэ?
 - A. Эрэг нь хоцорч нуур нь наашаа ирж явна.
 - B. Буйр нуур элдэв домгийг дотроо залгин үл цалгин дүнсийнэ.
 - C. Эх орондоо хайртай Буйр нуур очсон болгоныг хайраараа бүүвэйлнэ
 - D. Мэнэнгийн талд мэлтийсэн их ус хаашаа ч явалгүй нутгаа сахина.
3. “Дорнын тал түүн дээр орших Буйр нуурыг хамгаалалтдаа аваад нэмээд жаахан тохижуулчих юм бол дэлхийд өрсөлдөгчгүй гайхамшигт аяллын бүс нутаг болох боломжтой.” гэсэн санааг батлах баримтыг сонгоорой.
 - A. Дээгүүр нь машинтай давхих нь байтугай гишгэхэд хиртэм орчлонд ганц хувь үлдсэн гудас билээ.
 - B. Газар нутаг бас ингэж хамаагүй хязгааргүй үргэлжилдэг гэж үү?. Болоогүй юу?” гэж анх очсон хүн болгон гайхдаг
 - C. Аялж жуулчлахад хамгийн аятайхан газрын тоонд CNN-ийнхэн манай Монголын Хөвсгөл, Тэрхийн цагаан нуурыг багтаасан гэнэ.
 - D. Орчин үед Монгол төдийгүй хотожсон, иргэншсэн болгонд тархиныхаа ядаргааг тал нутгаар тайлах онош гараад байна.
4. “Нуурын ус цагариг үүсгэн дотогшоо огшиж бууриа харьд үлдээнэ.” гэсэн өгүүлбэрт байгаа “дотогшоо огшиж” гэсэн холбоо үг ямар утгаар орсон бэ?
 - A. омогшиж гэсэн утга
 - B. ширгэж гэсэн утга
 - C. цагариг үүсгэж гэсэн утга
 - D. мэлтгэнэж гэсэн утга
5. “Хоёр мянган оны эхэн үед хот руу шилжин суурьших нь их байсан бол **орчин үед** Монгол төдийгүй хотожсон, иргэншсэн болгонд тархиныхаа ядаргааг тал нутгаар тайлах онош гараад байна” гэсэн өгүүлбэрийн цагийн утгат үгийг зохиолч ямар зорилгоор ашигласан бэ?

- A. Өнгөрсөнд үнэлэгдээгүй зүйл орчин үед үнэлэгддэг болсон гэсэн эсрэг санааг гаргах зорилготой
 - B. Өнгөрсөнд тайлж чадаагүй ядаргааг орчин үед тал нутгаар тайлах нь зөв гэсэн санааг батлах зорилготой
 - C. Орчин үед хотжилт, иргэншилт бий болсноор тархи ядардаг болсон гэсэн санаагаа лавшруулах зорилготой
 - D. Орчин үе нь хотжилт, иргэншилтийг бий болгоод зогсохгүй тархийг ядраадаг гэсэн санааг нөхцөлдүүлэх зорилготой
6. Хэрэв чи “Дээгүүр нь машинтай давхих нь байтугай гишгэхэд хиртэм орчлонд ганц хувь үлдсэн гудас билээ” гэсэн зохиолчийн санаатай санал нэгдэж байвал доорх сэтгэгдлийн аль нь чинийх вэ?
- A. Дэлхийд өрсөлдөгчгүй гайхамшигт аяллын бүс нутагтай болох боломжтой гэж бодохоор баяртай байна.
 - B. Үхтлээ хамгаалж, үгүйртлээ хадгалж баймааж авч хоцорчхоод, өнөөдөр хүн төрөлхтөнд зүгээр л бэлэглэчихнэ гэхээр харамсалтай байна.
 - C. Ус нуур нь хүртэл эх орноо руугаа эргэж ирж байхад бид чухам эх орондоо юу үлдээж, харьд юугаа зөөж аваачиж өгч байгаа билээ гэхээс харуусал төрж байна.
 - D. Тархиныхаа ядаргааг тайлах тал нутагтай, түүгээрээ дэлхийд ялгарч чадаж байгаагаараа бахархаж байна.
7. Бичиж байгаа зүйлдээ эшлэл, зүүлт, ном зүйг хийсний ач холбогдол юу вэ?
- A. Өөрийн хэрэгцээтэй мэдээллийг олсон.
 - B. Бичигчийн гаргасан санааг үнэн гэдгийг батална.
 - C. Оюуны өмчийн санамсаргүй хулгайгаас сэргийлнэ.
 - D. Хэр гүнзгий уншиж судалснаа харуулна.
8. “Нуурын гүн тийш бараа тасартал алхаж болно.” гэсэн өгүүлбэрийг шалтгааны утгаар дэлгэрүүлэхэд тохирох нь аль вэ?
- A. Буйрт бас өөрийн гэсэн үүрэг бий тул
 - B. Торгон элс шаргалтан байхад
 - C. Ус ердөө төө хүрэхгүй гүнзгий учир
 - D. Наян километр урт, хорин километр өргөн
9. “Тохой өндөр өвсний ёроолоор зулсан зам арван алхмын цаанаас яаж харагдах вэ.” гэсэн өгүүлбэрийн гишүүн өгүүлбэрийг тодорхойлоорой.
- A. Тодотгол гишүүн өгүүлбэр
 - B. Шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэр
 - C. Шууд тусагдахуун гишүүн өгүүлбэр
 - D. Байц гишүүн өгүүлбэр
10. Үгийн утгын тайлбар тольд утга зохиолын эшлэлийг яаж тэмдэглэх вэ?
- A. Ром тоогоор
 - B. Бүх үсэг томоор
 - C. Налуугаар *italic*
 - D. Дугуй хаалтад

Үндэсний бичгийн даалгаврууд

11. Шинжлэх ухааны тодорхойлолтыг зөв хөрвүүлсэн өгүүлбэр аль вэ?

ᠴᠢᠬᠢᠯᠭᠠᠨ ᠭᠢᠳᠡᠯ бол сөрөг цэнэгтэй
электронуудын урсгал юм.
ᠴᠢᠬᠢᠯᠭᠠᠨ ᠭᠢᠳᠡᠯ бол сөрөг цэнэгтэй
элементүүдийн урсгал юм.
ᠴᠢᠬᠢᠯᠭᠠᠨ ᠭᠢᠳᠡᠯ бол сөрөх цэнэгтэй
элементүүдийн урсгал юм.
ᠴᠢᠬᠢᠯᠭᠠᠨ ᠭᠢᠳᠡᠯ бол сөрөх цэнэгтэй
электронуудын усгал юм.

- A. Цахилгаан гүйдэл бол сөрөг цэнэгтэй электронуудын урсгал юм.
- B. Цахилгаан гүйдэл бол сөрөг цэнэгтэй элементүүдийн урсгал юм.
- C. Цахилгаан гүйдэл бол сөрөх цэнэгтэй элементүүдийн урсгал юм.
- D. Цахилгаан гүйдэл бол сөрөх цэнэгтэй электронуудын усгал юм.

12. “ᠰᠠᠭᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤᠨ ᠨᠠᠭᠢᠨ ᠭᠡᠮᠡᠭᠡᠨ ᠰᠤᠶᠢᠨ ᠰᠤᠶᠢᠨ ᠰᠤᠶᠢᠨ” цээрлэх ёстой холбоотой өгүүлбэрийг зөв уншаарай.

- A. Ухсан нүхийг боолгохгүй орхихыг цээрлэдэг.
- B. Усан нүүдлийг буулгахыг цээрлэдэг.
- C. Ухсан нүхийг булахгүй орхихыг цээрлэдэг.
- D. Усан нүхийг боолгохгүй оргихыг цээрлэдэг.

13. “ᠰᠡᠬᠡᠢ” хэмээх өвөрмөц бичлэгтэй үгийг кириллээр зөв хөрвүүлснийг олоорой.

- A. сөөхий
- B. шүүгээ
- C. шүхэр
- D. сөх

14. “ᠬᠢᠷᠠᠭᠴᠢ” хэмээх үгээс өөр язгууртай /төрөл биш/ үг аль вэ?

- A. харагч
- B. харц
- C. хараа
- D. харз

15. “золгох ёс” гэсэн холбоо үгийг үндэсний бичгээр зөв бичсэнийг олоорой.

A.

ᠵᠣᠯᠭᠠᠬᠤ ᠶ᠋ᠢᠰ

B.

ᠵᠣᠯᠭᠠᠬᠤ ᠶ᠋ᠢᠰ

C.

ᠵᠣᠯᠭᠠᠬᠤ ᠶ᠋ᠢᠰ

D.

ᠵᠣᠯᠭᠠᠬᠤ ᠶ᠋ᠢᠰ

Уран зохиолын даалгавар

16. Махабхарата туулийн “Эзэн хаан чи соёрх би чамд аянгын бурхан Индрагийн тэнгэрийн ордон шиг бөгөөд энэ дэлхий дээр урьд хожид байгаагүй тийм орд босгож өгье.” гэсэн хэсгийн хам сэдвийг олоорой.

- A. Түүхийн хам сэдэв
- B. Улс төрийн хам сэдэв
- C. Нийгмийн хам сэдэв
- D. Шашны хам сэдэв

17. Хэрвээ чи А. Чехов “Хамелеон” өгүүллэгийн “Хүний амьдралд хүнлэг сэтгэл чухал биш болж гэдгийг харуулсан” гэсэн зохиогчийн санаатай санал нийлж байвал зохиолын аль хэсгийг өөрийн үзэл бодлоо батлах баримт болгон авах вэ?
- A. Эрхэм түшмэл ухаантай хүн тул хэн нэгэн худал хэлж байгааг, хэн тэнгэрийн өмнө шударгаар үнэн үг хэлж байгааг мэднэ.
 - B. Энэ үнэтэй цайтай ч нохой байж мэднэ. Аа, чи алиа гайхал гараа буулга. Хуруугаа дэмий гозгонуулах хэрэггүй. Чи өөрөө буруутай.
 - C. Цагдан байцаагч түшмэл Очумелов шинэ шинель өмсөөд гартаа боодолтой юм барьж, хотын зээлээр явж байна.
 - D. Генералын нохой болохоор сайн үүлдрийн үнэтэй, генералын нохой хүн хаздаггүй, генералын дүүгийн нохой сэргэлэн, ...
18. О.Бальзак “Эцэг Горио” туужаар нийгмийн ямар асуудлыг хөндсөн бэ?
- A. Хүн мөнгөнөөс, шуналаас болоод адгууснаас дор болдгийг харуулсан
 - B. Эцэг хүний үр хүүхдээ гэсэн энэрэнгүй сэтгэлийг харуулсан
 - C. Эцэг эхээ хайрладаггүй хүний жигшим дотоод ертөнцийг харуулсан
 - D. Дээдсийн хүрээлэнд орох гэж тэмцэлдэж байгааг харуулсан
19. “Нарангэрэлт дагина тууж”- ийн Нарангэрэлийн дүрийн зан төрхөд үл тохирох тодорхойлолтыг сонгоорой.
- A. Зорилго нь тууштай
 - B. Зан чанар нь ямагт эерэг
 - C. Бусдаас бурууг хайдаггүй
 - D. Аргагүйн эрхэнд бууж өгсөн
20. А.Доде “Сүүлчийн хичээл” зохиолын “Эльзас ба Лотарингийн сургуулиудад герман хэл заах шийдвэр ирэв.” гэсэн хэсэгт хамаарах дотоод орчныг сонгоорой.
- A. Баяр хөөртэй, таатай орчинд өрнөсөн
 - B. Гунигтай, уйтгартай орчинд өрнөсөн
 - C. Түгшүүртэй, айдастай орчинд өрнөсөн
 - D. Хүлээлт, догдлолтой орчинд өрнөсөн

Санамж:

- ✓ Хоёрдугаар хэсгийн даалгавар сонгох биш, харгалзуулах даалгавар тул хариултын хуудасны 2-р хэсэгт будаж тэмдэглээрэй.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Магелланы алдсан хоног буюу газар зүйн цаг

1519 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр хүн төрөлхтний түүхэн дэх анхны дэлхийг тойрсон аялал Испанийн эргээс эхэлжээ. Агуу Магелланаар ахлуулсан 5 усан онгоц, 270 аялагч их аянд гарснаас ганц Викториа онгоц арван наймхан зоригтон дэлхийг бүтэн тойроод ногоон хошуунд Африкийн баруун эргийн хойг - Cape Verde эсэн мэнд ирсэн билээ.

Усан цэргүүд эрэг дээр буунгуутаа нэг л зүйлд будилж, туйлаас их гайхсан гэдэг. Тэдний машинд нарийн хөтөлсөөр ирсэн усан онгоц дээрх хуанли ёсоор лхагва гараг болж байсан бол их газар дээр өөрөөр хэлбэл орхин одсон нутагт нь пүрэв гараг болж байх нь тэр. Гарцаагүй зөв тоолсоор байгаад бүтэн хоног алдчих гэж. Өнөөдөр хэний ч гайхахааргүй энэ хоногийн алдагдал 16 дугаар зууны боловсролтой сэхээтнүүдийн тархийг гашилгаж, санааг зовоосон байна.

2.1 Мэдээллийн үнэн худлыг нягтлаарай.

№	Мэдээлэл	Үнэн	Худал
a	Хүн төрөлхтөн арван зургаадугаар зуунд анх дэлхийг тойрон аялсан	1	2
b	Аялагчид усан онгоц дээр хуанлийг буруу хөтөлсөн	1	2
c	Гарцаагүй зөв тоолсоор байгаад бүтэн хоног алдсаны учир нь дэлхийн цагийн бүсчлэлтэй холбоотой.	1	2
d	Агуу Магелланаар ахлуулсан 5 усан онгоц, 270 аялагч их аянд гарч, дэлхийг бүтэн тойрсон.	1	2
e	Энэ хоногийн алдагдал 16 дугаар зууны боловсролтой сэхээтнүүдээс авхуулаад өнөө хүртэл эрдэмтдийн тархийг гашилгаж, санааг зовоосоор байна.	1	2

2.2. Зохиолын хэсгүүдийг дүрслэх ур маягтай зөв харгалзуулаарай. Нэг ур маягт нэгээс дээш жишээ холбогдож болно гэдгийг анхаараарай.

№	Зохиолын хэсэг	№	Дүрслэх ур маяг
a	Тэгэхээр нь догшин Бака ургаа модыг орвонгоор нь булга татан Бхимасена руу шидэж гэнэ. /Махабхарата/	1	Хэтрүүлэл
b	Нүд нь гилбэлгээн мэт, толгой нь мангасын толгой мэт, соёо нь төмөр гох мэт, сүүл нь төмөр могой мэт байвай.	2	Хүншүүлэл
c	Алаг цэцэг гуныхарч гандав. Ариун ой гашуудаж бөхөлзөв. \Игорийн хорооны үг\	3	Адилтгал
d	Байлдааны бэлэн дуунаар Манцуйлуулж, Баатар дуулган доор Бүүвэйлүүлж, Жадны үзүүрээр угжуулсан, Жавхлант баатар эрс болсон юм. \Игорийн хорооны үг\	4	Ихэсгэл
e	Нүдээ ганц нэг хатгаагүй Хэчнээн төчнөөн хатгахад нь Цус дуслаар гараагүй Хар хүрэн цусан гол Газраар нэг урсах шиг болсон. \Эдип хаан\		